

## ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ӨНДӨРХААН НИСЭХ БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ЗАЙНААС ХИЙСЭН ДОТООД АУДИТ, ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТОВЧ ТАЙЛАН

2021.05.27

Улаанбаатар хот

ИНЕГ-ын даргын баталсан 2021 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн ИНЕГ-ын харьяа Хэнтий аймаг дахь Өндөрхаан нисэх буудлын үйл ажиллагаанд зайнаас дотоод аудит, хяналт шалгалт хийх тухай 21/06 тоот удирдамжийн хүрээнд дотоод аудит, хяналт шалгалтыг хийлээ.

Батлагдсан удирдамжийн дагуу ИНЕГ-ын ДАА-ны санхүүгийн хяналтын мэргэжилтэн Ц.Оюут 2021 оны 04 дүгээр сарын 07-ны өдрөөс 2021 оны 04 дугаар сарын 30-ны өдрийг дуусталх хугацаанд дотоод аудитыг хийсэн.

ИНЕГ-ын даргын баталсан удирдамжийн хүрээнд Хэнтий аймаг дахь Өндөрхаан нисэх буудлын 2020 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс 2021 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацааны үйл ажиллагааны захиргаа, хүний нөөцийн үйл ажиллагаа, нягтлан бодох бүртгэл, цалин хөлсний бодолт, дотоод хяналт, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орон тооны бус багийн үйл ажиллагаа, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт зэргийг үндсэн баримт нотолгоонд тулгуурлан зайнаас шалгаж зарим эргэлзээтэй зүйлүүд дээр холбогдох албан тушаалтнаас тайлбар, тодруулга авч ажиллалаа.

Дотоод аудит, хяналт шалгалтын хамрах хугацаанд тус нисэх буудлын дарга нийт 13 тушаал гаргасны 8 нь буюу дийлэнх нь алдаа дутагдалтай байгаа нь тушаал шийдвэрийн боловсруулалт, түүнд тавигдаж буй хяналт сул байгааг харуулж байна.

Дотоод хяналтын багаас төлөвлөгөөт ажлуудын гүйцэтгэл болон тайлан бичилт хангалтгүй байна.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль болон Монгол Улсын Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/01 дүгээр тушаал, “Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн 253 дугаар тушаалуудыг өөрийн байгууллагад хэрэгжүүлэн ажиллах төлөвлөгөө гаргасан хэдий ч ажлын гүйцэтгэл хангалтгүй түвшинд байна.

Шилэн дансны мэдээллийг буруу оруулж байсан дутагдал багассан байна.

Аудитын шалтгалтын үр дүнд гарсан алдаа, дутагдлыг засаж, залруулах талаар тус нисэх буудалд 5 зөвлөмж өгсөн болно.

ДОТООД АУДИТЫН АЛБА